



Үнийн санал ирүүлэх урилга

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” нь эрх бүхий тендерт оролцогчдоос СЕР-1 дугаар бүхий “ДАМБАДАРЖАА ДЭД ТӨВИЙН 83 ДУГААР ШУГАМЫН УС ТҮГЭЭХ БАЙРНЫ ТОХИЖИЛТЫН АЖИЛ” тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Барилга, хот байгуулалтын яамны **БА-8.1** тусгай зөвшөөрлийн суурь шаардлагыг хангасан, хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл эзэмшигч байна.
- Сүүлийн 3 жилд (2022, 2023, 2024) амжилттай эсхүл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, мөн санал болгож буй ажилтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд оролцсон байх, ингэхдээ тендерт оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнэлгээ нь **61.0 сая төгрөгөөс** доошгүй байна. Тендерт оролцогчийн гүйцэтгэсэн ажлын ижил төстэй байдлыг Хоёрдугаар хэсэг (Техникийн тодорхойлолт ба бусад шаардлага)-т тодорхойлсны дагуу тухайн ажлын биет хэмжээ, онцлог чанар, иж бүрдэл, арга барил, технологи болон бусад шинжэд үндэслэн тодорхойлно. Тус шаардлагыг дангаар оролцогч этгээд заавал хангах бөгөөд түншлэлийн хувьд түншлэлийн аль нэг гишүүн заавал хангана.
- Тус ажлыг гүйцэтгэхэд шаардагдах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, зээлийн шугам, зээлжих эрхийн тодорхойлолт мөн бусад санхүүжилтийн эх үүсвэрийг (гэрээний урьдчилгаа төлбөр үүнд хамаарахгүй) олж авах эрхтэй, эсхүл авах боломжтой гэдгээ илтгэн мэдээлэх шаардлагатай. Шаардагдах түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн доод хэмжээ нь санал болгосон тендерийн үнийн дүнтэй тэнцүү байна. Тус шаардлагыг дангаар оролцогч этгээд заавал хангана. Харин түншлэлийн хувьд түншлэлийн гишүүн тус бүр шаардлагын 25-аас доошгүй хувийг заавал хангах, түншлэлийн аль нэг гишүүн шаардлагын 40-ээс доошгүй хувийг заавал хангах, түншлэлийн бүх гишүүд шаардлагыг заавал хангана.

Танай аж ахуйн нэгж нь тус ажлыг гүйцэтгэх дээрх шаардлагуудыг хангасан бөгөөд сонирхож байвал оролцох тухай мэдүүлгээ procurement@ub-subcenter.mn цахим шуудангаар ирүүлнэ үү. Мэдүүлэг хүлээн авсны дараа үнийн санал ирүүлэх урилга, маягт, техник тодорхойлолт болон холбогдох материалыг хариу цахимаар илгээх болно.

Үнийн саналыг 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 15:00 цагаас өмнө Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн доорх хаягаар дугтуйлж, битүүмжилсэн байдлаар ирүүлнэ.

Хаяг: "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төсөл, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу 1, Амарын гудамж-2, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар. Утас: 70003099